

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ДЭД ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
	ИТХ-ын 2016 оны 56-р тогтоол	Зорилго: Хүүхдийн шүд цоорох өвчлөлийн түвшинг тогтоон, шүдний өвчлөлд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийн хяналтыг сайжруулан, байгууллага, хамт олон, иргэдийн идэвхитэй оролцоонд тулгуурласан урьдчилан сэргийлэх, эмчлэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэн, хүүхдүүдийн дундах шүд цоорох өвчлөлийн тархалтыг бууруулна.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улс, орон нутгийн төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЭМТ, ӨЭМТ, СДЭ, ЭМГ, БОЭТ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: АЗДТГ, СЗДТГ
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Шүдний өвчлөлийг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тогтоох, бууруулах Зорилт 2. Дэвшилтэт технологид суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн иргэд, хүүхдийн байгууллага, эцэг эх, хүүхэд гэр бүлийн идэвхитэй оролцоонд тулгуурласан эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулах Зорилт 3. Амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж, чадавхижуулах, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын үйл ажиллагааг өргөжүүлэх
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал) Үүнд: Багц 1 Багц 2 (г.м)
		Төсөв (он)
		Гүйцэтгэл
		Хувь
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт: 1-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Шүд цоорох өвчигий тархалтыг тогтоон, эрсдэлт хүчин зүйлийн хяналт,	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн шүдний кабинетыг Лаборатори 1-р сургуульд байгуулан 2 дугаар сарын 28-ны өдөр албан ёсоор нээлтээ хийн үйл ажиллагаа явуулж байна. Хүүхдийн шүдний кабинетад шаардлагатай тоног төхөөрөмж, эм урвалжийн худалдан авалтыг хийж нөөц бололцоог ханган ажиллаж байна.

тандалтыг сайжруулснаар эмчлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг орчин үеийн аргад суурилан хэрэгжүүлснээр шүд цоорох өвчний тархалтыг бууруулсан байна.	Кабинетийн үйл ажиллагааны ажиллах журам боловсруулж, аймгийн засаг даргаар батлуулан холбогдох байгууллагад хүргүүлж, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 онд давхардсан тоогоор сургууль, цэцэрлэгийн 2-7 настай нийт 4000 гаруй хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаас эрүүлжүүлэх эмчилгээг 3000 гаруй хүүхдэд хийсэн. Лаборатори 1-р сургуулийн 6-7 настай хүүхдүүдийн шүд цоорлын тархалтыг 5 хувь, цэцэрлэгийн 2-5 настай хүүхдүүдийн шүд цоорлын тархалт 11 хувиар бууруулан ажилласан байна.
2-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд боловсрол, хүүхдийн байгууллага, эцэг, эхийн хамтын оролцоо нэмэгдэн, шүд цоорох өвчний дэвшилтэд технологид суурилсан урьдчилан сэргийлэх аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн боловсролын түвшинг нэмэгдүүлнэ.	Шүдний кабинетийн тохижилтыг хийх, мэдээлэл сургалт сурталчилгааны материалыг боловсруулан, шүдний картыг боловсруулан 7 хоног бүр хэвлэн олшруулж хүүхдийн шүдний кабинетаар үйлчлүүлж буй хүүхэд бүр дээр карт нээж эмчилгээ үйлчилгээндээ хяналт хийж, бүртгэл мэдээлэлийн баазыг үүсгэн ажиллаж байна. Шүдний тоног төхөөрөмж эм урвалжийн худалдан авах ажиллагааны техникийн үзүүлэлтийг боловсруулан холбогдох байгууллагад хүргэсэн байна. Ноён сумын СДЭ-ийн шүдний эмчийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай эм урвалжийг хуваарилж, ажиллах нөхцөлийг бүрдүүлээ. Эрүүл мэндийн боловсрол олгох 4 төрлийн самбар, 9 төрлийн материалыг 4500 ширхэгийг хэвлэн олшруулж сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон шүдний кабинетад хуваарилан өгсөн.
3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: Эрүүл мэндийн байгууллагуудын болон цэцэрлэг, сургуулийн эмч ажилчдыг чадавхижуулан, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлснээр тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын оролцоонд тулгуурласан шүд амны хөндийн эрүүл мэндэд ээлтэй дэмжлэгт орчин	АШУҮИС-ийн Нүүр ам судлалын сургуулийн Урьдчилан сэргийлэх тэнхимтэй хамтран “Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт”-ыг зохион байгуулсан. Сургалтад анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сургууль, цэцэрлэгийн эмч 35 хүнийг хамруулж гарын авлага, шүдний муляж, үзүүлэн материалаар хангасан байна. Иргэдэд зориулсан шүдээ хэрхэн зөв угаах видео нэвтрүүлгийг орон нутгийн телевизтэй хамтран бэлтгэж ард иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэсэн. Мөн цэцэрлэгийн насны хүүхэдтэй 500 гаруй эцэг эхчүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Ханбогд СДЭ, Цогтцэций СДЭ, Ноён СДЭ эмнэлгүүдэд нийт 26,332,350 төгрөгний, тус бүр 8777450 төгрөгний эм материал урвалжийг хувиарлан өгснөөр дээрх сумдуудад хүүхдийн шүд цоорлын тархалтыг бууруулан ажиллах нөхцөлөөр хангасан. Мөн хөтөлбөрийн хүрээг өргөтгөн шинээр баригдсан “Шим билэг” өрхийн эрүүл мэндийн төвд шинээр шүдний кабинет нээн ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хөтөлбөрийн төсвийн зарцуулалтын 62% нь тоног төхөөрөмж, 18% нь эмчийн цалин урамшуулал, 15% нь сургалт сурталчилгаа, 5% нь үзлэг оношилгоонд зарцуулагдсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 73%-тай байна.

	бүрдэнэ.											
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Давуу тал: Сургуулийн болон цэцэрлэгийн насны хүүхдүүдийн шүд цоорлын тархалтын хувь дунджаар 8%-аар буурсан үзүүлэлттэй байгаа нь цаашид цоорлын тархалтыг хөтөлбөр хэрэгжсэнээр тогтвортой бууруулах боломжтойг харуулж байна. Шүдний кабинетийг нэмэгдүүлж байгаа нь хамралтыг нэмэгдүүлэх ая холбогдолтой мөн БОЭТ-ийн шүдний амбулторын үзлэгийн ачаалал багасаж иргэдэд хурдан шуурхай үйлчлэх боломжтой болсон. Сул тал: Орон нутгийн мэдээллийн байгууллагууд хамтран ажиллах болон иргэдэд мэдээлэл түгээхдээ өндөр төлбөртэй байна. Эцэг эхчүүдийн хүүхдийнхээ эрүүл мэнд ялангуяа амны хөндийн эрүүл мэндэд тавих анхаарал сул байна. Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн дарга эрхлэгч нарт хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн. Цаашид анхаарах асуулдал: Сургалт сурталчилгааны төсвийг нэмэгдүүлэн цахим мэдээлэл ашиглан иргэдэд мэдээлэл түгээх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. БСУГ-тай хамтран анги, бүлэг удирдсан багш нарын удирдах чадварыг дайчлан эцэг эхчүүдтэй холбоо тогтоож сайн эрүүлжсэн, сайн дадал хэвшил эзэмшсэн анги бүлгийг сонгон шалгаруулж урамшуулах, удирдсан багшид ур чадварын нэмэгдэл олгодог болохын тулд хөтөлбөр хэрэгжүүлэгчдийн урамшууллын асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ байна.									
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.									
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3						
		95%	3	100%	90%	95 %						
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ									
			... %									

Хэрэгжилт гаргасан..... /албан тушаалтан/

Хянасан /албан тушаалтан/